

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М. Батсуурь
Улаанбаатар хот	Утас: 70453317 Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn
2023 он	Аудитын менежер: М. Бат-Амгалан Утас: 70453799 Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
	Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Ариун төгс оршихуй Аудит" ХХК-ийн аудитор: В.Сэлэнгэ
	Утас: 9411-1882 Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/88/АА-СТА-ТЦЗ
танай _____ -ны № _____ -т

ХОВД СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.БАДАМНЯМБУУ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200174

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>86,825,837.96</u>	<u>93,622,950.96</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	5,335,017.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	5,335,017.00
3121	Төгрөг	00.00	5,335,017.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	5,335,017.00
33	АВЛАГА	14,585,074.00	72,106.00
335	Бусад авлага	14,585,074.00	72,106.00
3351	Байгууллагаас авах авлага	14,585,074.00	69,089.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	3,017.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,240,763.96	88,215,827.96
35100	Түүхий эд материал	475,000.00	
35130	Эм боох материал	475,000.00	
354	Хангамжийн материал	71,765,763.96	88,215,827.96
35410	Бичиг хэргийн материал	892,500.00	75,000.00
35420	Аж ахуйн материал	39,869,342.00	44,011,906.00
35460	Хүнсний материал	1,267,660.00	2,391,260.00
35470	Бусад хангамжийн материал	29,736,261.96	41,737,661.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>562,189,355.59</u>	<u>554,527,096.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	562,189,355.59	554,527,096.16
392	Биет хөрөнгө	548,083,355.59	540,421,096.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	593,043,799.99	610,043,799.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70,140,720.50	-91,961,436.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,000,000.00	-6,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,019,467.00	45,019,467.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,838,966.94	-35,735,383.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,339,308.00	25,969,308.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,242,785.96	-16,817,912.47
39217	Ном	3,903,254.00	3,903,254.00
393	Биет бус хөрөнгө	14,106,000.00	14,106,000.00
39301	Програм хангамж	258,750.00	258,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-258,750.00	-258,750.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,106,000.00	14,106,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>649,015,193.55</u>	<u>648,150,047.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,455,041.00</u>	<u>346,885.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,455,041.00	346,885.00
413	Өглөг	1,455,041.00	346,885.00
4136	Бусад өглөг	1,455,041.00	346,885.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,023,390.00	346,885.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	647,560,152.55	647,803,162.12
51	Засгийн газрын хувь оролцоо	647,560,152.55	647,803,162.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	669,725,675.00	669,725,675.00
51101	Өмч: - төрийн	669,725,675.00	669,725,675.00
512	Хуримтлагдсан үр дүн	-128,190,075.44	-127,947,065.87
51210	Өмнөх үеийн үр дүн	-120,371,488.25	-128,190,075.44
51220	Тайлант үеийн үр дүн	-7,818,587.19	243,009.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	106,024,552.99	106,024,552.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	649,015,193.55	648,150,047.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	250,462,700.00	291,678,950.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,283,000.00	23,349,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,283,000.00	23,349,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,283,000.00	23,349,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,283,000.00	23,244,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,179,700.00	268,329,550.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	229,646,000.00	234,327,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,000.00	105,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	180,000.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,353,700.00	33,896,850.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,353,700.00	33,896,850.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	258,281,287.19	291,435,940.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	258,281,287.19	291,435,940.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	249,431,560.22	290,519,440.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,840,863.03	187,500,411.94
210101	Үндсэн цалин	121,331,039.86	135,715,481.66
210102	Нэмэгдэл	25,963,952.32	40,792,129.38
210104	Урамшуулал	13,505,870.98	10,992,800.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,780,711.00	22,818,888.00
210201	Тэтгэврийн даатгал	14,956,302.00	15,846,983.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,499,937.00	1,872,470.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,305,819.00	1,497,976.00
210204	Ажилгүйдлийн даатгал	274,417.00	323,148.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,744,236.00	3,278,311.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,589,901.00	16,317,300.00
210301	Гэрэл, цахилгаан	971,440.00	1,519,400.00
210302	Түлш, халаалт	14,618,461.00	14,618,400.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	179,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,840,539.00	5,024,001.00
210401	Бичиг хэрэг	775,900.00	413,260.00
210402	Тээвэр, шатахуун	1,565,597.00	2,657,205.00
210408	Бараа материал акталсны зардал	2,460,882.00	1,953,536.00
2105	Нормативт зардал	9,598,090.00	24,584,700.00
210502	Хоол, хүнс	9,010,990.00	24,584,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	629,000.00	810,000.00
210604	Урсгал засвар	629,000.00	810,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	868,830.00	372,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	487,000.00	372,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,241,626.19	33,092,139.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,411,580.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,643,200.00	2,388,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,598,426.19	27,292,259.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,849,726.97	916,500.06
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,349,726.97	916,500.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,349,726.97	916,500.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-7,818,587.19</u>	<u>243,009.57</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-7,818,587.19</u>	<u>243,009.57</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>248,539,800.00</u>	<u>268,434,550.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	105,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	105,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,539,800.00	268,329,550.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	229,646,000.00	234,327,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	540,100.00	105,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	180,000.00	105,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,353,700.00	33,896,850.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,353,700.00	33,896,850.00

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>248,539,800.00</u>	<u>263,099,533.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	248,539,800.00	263,099,533.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,690,073.03	262,183,032.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	165,022,886.03	187,413,111.94
210101	Үндсэн цалин	121,152,915.86	135,628,173.46
210102	Нэмэгдэл	25,963,952.32	40,792,135.12
210104	Урамшуулал	12,866,017.98	10,992,803.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,756,817.00	22,824,871.00
210201	Тэтгэврийн даатгал	15,312,518.00	15,968,690.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,668,851.00	1,817,281.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,370,463.00	1,453,945.00
210204	Ажилгүйдлийн даатгал	366,148.00	325,792.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,038,837.00	3,259,163.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,796,700.00	17,553,450.00
210301	Гэрэл, цахилгаан	971,440.00	1,519,400.00
210302	Түлш, халаалт	15,825,260.00	15,641,790.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	392,260.00
2105	Нормативт зардал	10,576,880.00	25,168,300.00
210502	Хоол, хүнс	10,097,980.00	25,168,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,557,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,557,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	868,830.00	372,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	487,000.00	372,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,308,700.00	8,051,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,065,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,308,700.00	1,986,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,849,726.97	916,500.06
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,349,726.97	916,500.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,349,726.97	916,500.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>5,335,017.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	5,335,017.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	5,335,017.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	669,725,675.00	106,024,552.99	-128,190,075.44	647,560,152.55

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	669,725,675.00	106,024,552.99	-128,190,075.44	647,560,152.55
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	243,009.57	243,009.57
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	669,725,675.00	106,024,552.99	-127,947,065.87	647,803,162.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	234,327,700.00	229,097,683.00	5,230,017.00	97.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,327,700.00	229,097,683.00	5,230,017.00	97.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,327,700.00	229,097,683.00	5,230,017.00	97.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,262,300.00	174,262,298.00	2.00	100%
210101	Үндсэн цалин	143,822,300.00	124,735,929.93	19,086,370.07	86.7%
210102	Нэмэгдэл	26,731,200.00	39,520,538.76	12,789,338.76	147.8%
210104	Урамшуулал	3,708,800.00	10,005,829.31	-6,297,029.31	269.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,003,400.00	21,243,785.00	759,615.00	96.5%
210201	Тэтгэврийн даатгал	15,118,400.00	14,849,715.00	268,685.00	98.2%
210202	Тэтгэмжийн даатгал	1,721,300.00	1,685,620.00	35,680.00	97.9%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,377,000.00	1,348,617.00	28,383.00	97.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	344,200.00	305,327.00	38,873.00	88.7%
210205	Эрүүл мэндийн даатгал	3,442,500.00	3,054,506.00	387,994.00	88.7%
2105	Нормативт зардал	29,241,900.00	25,168,300.00	4,073,600.00	86.1%
210502	Хоол, хүнс	29,241,900.00	25,168,300.00	4,073,600.00	86.1%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,000.00	372,000.00	72,000.00	83.8%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	444,000.00	372,000.00	72,000.00	83.8%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,376,100.00	8,051,300.00	324,800.00	96.1%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,066,100.00	6,065,000.00	1,100.00	99.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,310,000.00	1,986,300.00	323,700.00	85.9%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	234,327,700.00	234,432,700.00		
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	234,327,700.00	234,327,700.00		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	234,327,700.00	234,327,700.00		
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		105,000.00		

	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		105,000.00		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,335,017.00		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17.50	17.50		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	09.50	09.50		
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00		
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00		

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутаг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,998,400.00	33,085,349.94	8,913,050.06	78.70%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,998,400.00	33,085,349.94	8,913,050.06	78.70%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,998,400.00	33,085,349.94	8,913,050.06	78.70%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,816,400.00	13,150,813.94	665,586.06	95.10%
210101	Үндсэн цалин	13,816,400.00	10,892,243.53	2,924,156.47	78.80%
210102	Нэмэгдэл	0	1,271,596.36	-1,271,596.36	0
210104	Урамшуулал	0	986,974.05	-986,974.05	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,727,000.00	1,581,086.00	145,914.00	91.50%
210201	Тэтгэврийн даатгал	1,174,400.00	1,118,975.00	55,425.00	95.30%
210202	Тэтгэмжийн даатгал	138,100.00	131,661.00	6,439.00	95.30%
210203	ҮОМШӨ-ний даатгал	110,500.00	105,328.00	5,172.00	95.30%
210204	Ажилгүйдлийн даатгал	27,600.00	20,465.00	7,135.00	74.10%
210205	Эрүүл мэндийн даатгал	276,400.00	204,657.00	71,743.00	74.00%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,655,000.00	17,553,450.00	8,101,550.00	68.40%
210301	Гэрэл, цахилгаан	2,450,000.00	1,519,400.00	930,600.00	62.00%
210302	Түлш, халаалт	22,720,000.00	15,641,790.00	7,078,210.00	68.80%
210303	Цэвэр, бохир ус	485,000.00	392,260.00	92,740.00	80.80%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800,000.00	800,000.00	0.00	100.00%
210604	Урсгал засвар	800,000.00	800,000.00	0.00	100.00%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,998,400.00	33,085,349.94		
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,998,400.00	33,085,349.94		

320001	Орон нутгийн төсвөөс	41,998,400.00	33,085,349.94	
--------	----------------------	---------------	---------------	--

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд сумын цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм. Энэхүү чиг үүргийнхээ хүрээнд тус цэцэрлэг нь "Сургах тоглоомын тохилог орчин бүрдүүлж, хүүхэд нэг бүрийг судалж, чөлөөт байдал, бүтээлчээр сэтгэх чадварыг хөгжүүлнэ" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 865.1 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	5,335.0	5,335.0
Авлага	14,585.1	72.1	-14,513.0
Бараа материал	72,240.7	88,215.8	15,975.1
Үндсэн хөрөнгө	562,189.3	554,527.1	-7,662.2
Нийт хөрөнгө	649,015.2	648,150.1	-865.1
Өр төлбөр	1,455.0	346.9	-1,108.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	647,560.2	647,803.2	243.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	649,015.3	648,150.0	-865.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 5,335.0 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлагын хувьд өмнөх онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой 2021 оны 12-р сарын 31-нд хөрөнгө хүлээн зөвшөөрөлтийн шалгуур бүрэн хангаагүй байсан учир шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн. Харин 2022 онд хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуурт бүрэн нийцсэн учир авлагыг 14,000.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88,215.8 мянган төгрөг болж 15,975.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд Шимт боловсролын байгууллагаас нийлүүлсэн 14,000.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалаар ангилан бүртгэсэн сургалтын хэрэглэгдэхүүний өртөг зонхилж нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 554,527.1 мянган төгрөг болж 7,662.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд 17,000.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 2,630.0 мянган төгрөгийн хөрөнгө хандиваар хүлээн авч, тайлант хугацааны элэгдлийн зардлаар 27,292.3 мянган төгрөг тооцож бүртгэсэн байна.

Өр төлбөр 1,108.1 мянган төгрөгөөр буурсан байна. Өр төлбөр дансны үлдэгдэл 346.9 мянган төгрөг нь хувь хүнд өгөх өр төлбөр байна. Энэ онд харилцагч байгууллагуудтай холбоотой өр төлбөргүй болох нь тооцооны үлдэгдлээр баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 647,803.2 мянган төгрөг болж 243.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 234,327.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 41,998.4 мянган төгрөгөөр тус тус тооцон нийт 276,326.1 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотголоор өөрчлөлт ороогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 234,327.7 мянга, орон нутгийн төсвөөс 41,998.4 мянга, нийт 276,326.1 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 234,327.7 мянга, орон нутгийн төсвөөс 33,896.9 мянга, өөрийн орлого 105.0 мянга, нийт 268,329.6 мянган төгрөгийн төсвийг бүрдүүлсэн байна. Орон нутгийн төсвийн санхүүжилт 8,101.6 мянган төгрөгөөр дутуу ирсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл улсын төсөв 229,097.7 мянга, орон нутгийн төсөв 33,085.3 мянга, нийт гүйцэтгэл 262,183.0 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 5,230.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласантай холбоотой байна. Тайлант онд төсвийн хэмнэлт 916.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Улсын төсөв	234,327.7	229,097.7	5,230.0	97.7%
2	Орон нутгийн төсөв	41,998.4	33,085.3	8,913.1	78.8%
	Нийт	276,326.1	262,183.0	14,143.1	94.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн аудитор В.Сэлэнгэ нар гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Ховд сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ариун төгс оршихуй аудит” ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан тул 2021 оны санхүүгийн тайлан үр дүнгийн тайлангийн нийт зардал 239,685.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,396.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 291,435.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 2,914.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,331.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ховд сумын цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа нь харилцан адилгүй ялгаатай байсан бөгөөд уг хугацаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлогод нарийвчлан тусгагдаагүй байна.

Үүнтэй холбоотой байгууллагын одоогийн мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн найруулж, шинэчлэх шаардлагатай байна.

Тус цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Тайлант хугацаанд 51,863.4

мянган төгрөгийн худалдан авалт хийснээс 10,801.7 мянган төгрөгийн худалдан авалт нь И-баримтаар баталгаажаагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ховд сумын цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“АРИУН ТӨГС ОРШИХУИ АУДИТ”
ХХК-ийн АУДИТОР

/В.СЭЛЭНГЭ/

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

